

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 4 сарын 29 өдөр

№ 02

Улаанбаатар хот

**2015 оны тайлан тэнцлийн
дүнг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Диспетчерийн үндэсний төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлан тэнцлээр нийт хөрөнгийг 14 884 427 683,16 /Арван дөрвөн тэрбум найман зуун наян дөрвөн сая дөрвөн зуун хорин долоон мянга зургаан зуун наян гурван төгрөг, арван зургаан мөнгө/ төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 14 011 420 548,55 /Арван дөрвөн тэрбум арван нэгэн сая дөрвөн зуун хорин мянга таван зуун дөчин найман төгрөг, тавин таван мөнгө/ төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 873007134,61 /Найман зуун далан гурван сая долоон мянга нэг зуун гучин дөрвөн төгрөг, жаран нэгэн мөнгө/ төгрөгөөр, эзэмшигчийн өмчийг 1 456 525 235,15 /Нэг тэрбум дөрвөн зуун тавин зургаан сая таван зуун хорин таван мянга хоёр зуун гучин таван төгрөг, арван таван мөнгө/ төгрөгөөр, нийт авлагыг 201 902 766, 85 /Хоёр зуун нэг сая есөн зуун хоёр мянга долоон зуун жаран зургаан төгрөг, наян таван мөнгө/ төгрөгөөр, богино хугацаат өглөгийг 3 627 100 666, 15 /Гурван тэрбум зургаан зуун хорин долоон сая нэг зуун мянга зургаан зуун жаран зургаан төгрөг, арван таван мөнгө/ төгрөгөөр, урт хугацаат зээл 9 800 801 781, 86 /Есөн тэрбум найман зуун сая найман зуун нэг мянга долоон зуун наян нэгэн төгрөг, наян зургаан мөнгө/ төгрөгөөр, татварын дараах ашиг 23 508 446,97 /Хорин гурван сая таван зуун найман мянга дөрвөн зуун дөчин зургаан төгрөг ерэн долоон мөнгө/ төгрөгөөр санхүүгийн тайлан тэнцлийн дүнг тус тус баталсугай.

2. Компанийн 2015 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, 2016 онд өртөг зардлыг бууруулах, аривлан хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, санхүүгийн төлбөрийн чадварыг сайжруулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал нарт даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ:**

Эрчим хүчний яамыг төлөөлж:


Д.ДЭЛГЭРЦОГТ

Сангийн яамыг төлөөлж:


В.ДАРХАНБААТАР